



## МОНГОЛБАНКНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

### НЭГ. ЗОРИЛГО

Эдийн засаг, статистик болон санхүүгийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг судлаач, эрдэмтэд болон оюутнуудыг дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлэхэд оршино.

### ХОЁР. СЭДВИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Банк санхүү
- 2.2 Эдийн засаг
- 2.3 Хууль, эрх зүй
- 2.4 Финтек
- 2.5 Санхүүгийн боловсрол
- 2.6 Уур амьсгалын өөрчлөлт, ногоон сэргэлт

### ГУРАВ. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

#### 3.1 Бүтээлийн агуулгын хувьд:

- Онол, арга зүйн үндэслэлтэй;
- Шинэлэг, оновчтой санал, санаачлага дэвшүүлсэн;
- Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан;
- Бодит байдалд хэрэгжиж болохуйц;
- Эконометрик, статистикийн арга хэрэгслүүдийг ашигласан;
- **Оюутны ангилалд** оролцох судалгааны ажлууд заавал удирдагч багштай байх;
- Бусдын ажлыг шууд хуулбарлаагүй;
- Судалгаанд ашигласан материалыг бүрэн дурдсан;
- Судалгааны шалгарсан болон шинэлэг арга хэрэгслүүдийг ашигласан байх;
- Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, дүгнэлт, зөвлөмжид хүрсэн байх;

#### 3.2 Оролцогчдын хувьд:

- Оролцогч нь оюутны болон судлаачийн аль ангилалд оролцохоо тодорхой бичих;
- Дотоодын болон гадаадын их дээд сургуулийн 2 ба түүнээс дээш курсийн оюутан байх;
- Судлаачийн ангилалд оролцогч нь эрхэлж буй ажил албан тушаал, мэргэжлээ тодорхой дурдах;
- Багаар оролцож болох ба гишүүдийн тоо 3-аас ихгүй байна;
- Бүтээлээ заавал 3 хувь хэвлэмэл байдлаар ирүүлэх.

#### 3.3 Бичгийн стандарт:

- Үсгийн фонт – Times New Roman /”Mon” өргөтгөлтэй фонт байж болохгүй/;
- Фонтын хэмжээ - 12;
- Мөр хоорондын зай – 1,5;
- Margins: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм;

- Цаасны хэмжээ: А4
- Бүтээлийн хуудасны тоо: 20-30;
- Товч мэдээлэл: Сэдвийн хүрээнд өөрийн судалгааны хураангуйг бичсэн байх;
- Бусад: Нүүр хуудсанд нэр, холбоо барих 2 утасны дугаар, и-мэйл хаяг, ажлын болон сургуулийн нэр, курс, мэргэжил, судалгааны ажлын нэрийг бичих;
- Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
- Илтгэл нь гарчиг, хураангуй, удиртгал, судалгааны хэсэг, дүгнэлт ном зүй гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдсэн байх;
- Оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах).

## **ДӨРӨВ. ХУРЛЫН ҮЕ ШАТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 4.1 Нэгдүгээр шат: Зохион байгуулах комисс бүтээлийг хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээн авч судалгааны ажлыг дүгнэх.
- 4.2 Хоёрдугаар шат: Монголбанк болон гадны төлөөлөгч нараас бүрдсэн багаар шүүлгэж дүнг гаргах, шалгарсан бүтээлүүдийг Монголбанкны албан ёсны вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээнэ.
- 4.3 Оюутны болон судлаачийн ангилалд тус бүр 5 ажлыг хоёрдугаар шатанд сонгон шалгаруулна.
- 4.4 Эхний шатанд шалгарсан судалгааны ажлуудыг 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 10.00 цагт цахим хэлбэрээр хэлэлцүүлнэ.
- 4.5 Эцсийн шатанд шалгарсан бүтээлүүдийн хэлэлцүүлэгт тавигдах шаардлага
  - Илтгэлийг PowerPoint эсвэл PDF файлыг хураангуйтай хамт ирүүлэх;
  - Илтгэл нь гарчиг, удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдсэн байх;
  - Илтгэл сэдвийн хүрээнд байгаа эсэх;
  - Шинэлэг санаа гаргасан байдал;
  - Илтгэх чадвар;
  - Санаагаа тодорхой хүргэх чадвар (ойлгомжтой, цэгцтэй);
  - Асуултад оновчтой хариулж буй байдал;
  - Үгийн сонголт, ярианы чадвар;
  - Илтгэлийн хугацаа: 10 минут.

## **ТАВ. ШАГНАЛЫН САН**

- 5.1 Оюутны ангилал
  - 1-р байр - Өргөмжлөл, 1 300 000 /Нэг сая гурван зуун мянган төгрөг/;
  - 2-р байр - Өргөмжлөл, 1 000 000 /Нэг сая төгрөг/;
  - 3-р байр - Өргөмжлөл, 700 000 /Долоон зуун мянган төгрөг/.
- 5.2 Судлаачийн ангилал
  - 1-р байр - Өргөмжлөл, 2 000 000 /Хоёр сая төгрөг/;
  - 2-р байр - Өргөмжлөл, 1 600 000 /Нэг сая зургаан зуун мянган төгрөг/;
  - 3-р байр - Өргөмжлөл, 1 300 000 /Нэг сая гурван зуун мянган төгрөг/.

## **ЗУРГАА. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ**

**Хугацаа:** 2022 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 17:00 цаг хүртэл бүтээлийг электрон хэлбэрээр [essay@mongolbank.mn](mailto:essay@mongolbank.mn) хаягаар хүлээн авна.

**Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “А” байр**

**Олон нийтийн санхүүгийн боловсролын төв**

Дэлгэрэнгүй мэдээллийг [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn) веб хуудаснаас

болон (976) 11-311240 утсаар лавлана уу.